

МОНГОЛЧУУДЫН ЦАЙНЫ НЭР ХЭЛ, СОЁЛЫН ШҮТЭЛЦЭЭНИЙ ИЛРЭЛ
БОЛОХ НЬ

Г.Ганзул¹

Дэлхий дээр олон улс үндэстэн оршин тогтнож, өөрийн үндэсний соёлыг бий болгон хөгжүүлж, хадгалан дараа үедээ өвлүүлсээр иржээ. Тиймээс аль ч улсын соёл, ахуй амьдрал, ёс заншил, хэл яриа нь өвөрмөц онцлогтой бөгөөд өөр хоорондоо давтагдашгүй юм. Тиймээс эдгээр онцлог нь хэл ярианы баялаг үгийн санг бүрдүүлдэг. Бид, монголчууд ямар цайны төрлийг хэрэглэж ирсэн, түүнийг нэрлэсэн ямар нэгжүүд монгол хэлэнд буйг тогтоох, эдгээр нэгжийг судалснаар монголчуудын соёл, тухайн тохиолдолд цайны соёл ба хэлний шүтэлцээг нэгэн бүлэг үгийн жишээн дээр харуулахыг зорьсон болно.

Хэл, соёлын шүтэлцээ үгийн сангийн түвшинд хамгийн түрүүнд илэрч, хэлний тодорхой тэмдэг, ямар ухагдахууныг өөртөө агуулж, байгаа, энэ нь хэлний нөгөө тэмдэгтэй агуулгын хувьд давхцаж байгаа эсэх нь хэлийг соёлтой холбож судлах урсгал зонхилох болсон өнөө үед ач холбогдолтой юм. (Н. Нансалмаа, 2005, 41)

Хүн аль нэг тодорхой асуудлыг шийдэхийн тулд аль нэг юм, үзэгдэлтэй харьцдаг. Ингэж харьцсаны үр дүнд хүн уг зүйл, юм үзэгдлийг (объект) таних боломжтой болно. Өөрөөр хэлбэл, судалж буй юмыг хүн бодит үйл ажиллагаандаа хэрхэн ашиглахаар зэхэж буй байдлаар танин мэдэх үйлийг тодорхойлж болно. (Н. Нансалмаа, 2011, 193) Танин мэдэхүй нь мэдлэгийг олж авах, ашиглах, хадгалах, дамжуулах, боловсруулахтай холбоотой үйл явц юм. Тэгвэл хэлний танин мэдэхүй нь хэлний хэрэглүүрийн тусламжтайгаар мэдлэг олж авах, хадгалах, дамжуулах үйл явц болно. (Н. Нансалмаа, 2005, 28)

Үүнийг тодорхойлохын тулд ертөнцийн хэлний зураглал чухал үүрэгтэй бөгөөд чухам юуг Ертөнцийн хэлний зураглал гэдэг вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Тэгвэл ертөнцийн хэлний зураглал нь а) нийт хүн төрөлхтний бодит ертөнцтэй харьцах харьцааны илрэл болох хэлний ерөнхий зураглал, б) тодорхой ард түмний соёл, ахуй, нийгмийн амьдрал, зан заншлын тусгал болдог байна. Энэ нь өөр ард түмэнд давтагдахгүй юм. Энэ нь үндэсний онцлог үгээр илэрнэ. Ертөнцийн хэлний зураглалын хэлбэрийг дараах байдлаар харуулав.

1. Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль

Бүрдүүвч 1



Хүснэгт 1

Чанарын ялгаатай ертөнцийн зураглалын субъект

Насанд хүрсэн хүний	Хүүхдийн
Хэвийн сэтгэцтэй хүний	Хэвийн бус сэтгэцтэй хүний
Соёл иргэншсэн	Хуучны ертөнцийн зураглал

Ертөнцийн хэлний зураглалыг үйл ажиллагаагаар нь:

- Ертөнцийн зураглалыг төсөөлж буй субъект (хэн)
- Ертөнцийн зураглалд төсөөлөгддөг юмс (юу)
- Үйл ажиллагааны үр дүн, чухамдаа ертөнцийн зураглал (Серебренников, Кубрякова, Постовалова, 1988, 32) гэж ангилан үзжээ.

Ундааны төрөл болох цай нь аль ч ард түмний ахуй, соёлын тусгал болох бөгөөд эрт дээр үеэс хэрэглэж ирсэн уламжлал билээ. Жишээлбэл, Монголын сүүтэй ба хар цай, Японы цайны ёслол, Шри-Ланкийн цейлон цай, Английн Липтон цай, Хятадын ногоон цай г.м.

Цайны нэр нь тухайн ард түмний амьдралын хэв маяг, эрхэлж ирсэн аж ахуй, бодит ертөнцийн аль хэсэгтэй ойр шүтэлцээтэй оршиж ирсний гэрч болдог. Үүнтэй уялдуулан бид “соёл” гэж юуг ойлгох вэ?

Америкийн судлаач Р. Ладо “Соёлыг ард түмний ёс заншилтай”-тай адилтган үздэг. (Р.

Ладо, 1989, 49) Энэ тухай эрдэмтэн Н. Нансалмаа “Энэ нь тодорхой ард түмэн түүхэн цаг хугацааны явцад хэвшин тогтсон амьдралын хэв маяг, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх хэрэгсэл болдог байна” гэж үзжээ. (Н. Нансалмаа, 1997) Түүнчлэн “Үг, холбоо үг нь тухайн орны түүх, хөгжил, соёл, уламжлал, ёс заншлыг илэрхийлдэг” гэж тэмдэглэжээ. (Томтогтох, Туяа, 2002, 190)

Тиймээс энэ үзэл баримтлалыг баримтлан “соёл” гэдэг нь ард түмний түүх, ёс заншил, уламжлал, амьдралын хэв маяг, амьдралын туршлага зэрэг болно гэж бид ойлгож байгаа юм.

Судалгааны үндсэн эх сурвалж нь:

1. П. Амаржаргал “Цайны алтан судар буюу энх мөнхийн цай” ДА., 2004
2. Г. Гонгоржав “Амтат цайны жор” УБ., 1992
3. И. Дамбажав, Алтан-Од, Солонго “Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж” УБ., 2006
4. Ерөнхий редактор Л.Болд “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” УБ., 2008
5. Я. Цэвэл “Монгол хэлний товч тайлбар толь” УБ., 1966
6. А. Лувсандэндэв, Ц. Цэдэндамба “Большой академический монгольско-русский словарь” М., 2001
7. Монсудар хэвлэлийн газар “Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг” УБ., 2009 толь бичиг, ном зохиолуудаас цайтай холбоотой нийт 182 нэгж түүвэрлэж, судалгаа, шинжилгээ хийлээ.

Цайны соёлыг ярихаас өмнө, цай хаанаас, яаж үүссэн талаар сонирхоцгооё. Гималайн цас мөсөөр хучигдсан сүрлэг уул нурууны доод бэлд малчид мал сүртэй хариулан бэлчээж, амар жимэр аж төрөн амьдран суудаг байжээ. Малчдын хэдэн хонь огт зүгээр байснаа гэнэт цовоо сэргэлэн болжээ. Малчид юунаас болов гэж гайхан харж ажигласаар байтал хонь нэгэн мөнх ногоон модонд хүрч очоод, түүний навчийг таслан амандаа хийж зажлан хивсний дараа гун ч удалгүй хөдөлгөөн нь сэргэн, гүйж харайх нь шаламгай болж байх шиг санагдсан. Тэгээд малчид энэ явдлыг машид сонирхон улмаар танин мэдэх, сонирхох төрөлхийн их хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөн өнөөх хонины идэж байсан ногоон навчийг авч хагаагаад, яг л үнэт эмийн ургамлын навч, цэцгийн хандыг хэрэглэдэг шигээ амтлан үзжээ. Тэгтэл түүний нөлөө санаснаас илүүтэйгээр бие, сэтгэлд зэрэг нөлөөлөн, бие тэнхрэн сэргэж чадал нэмсэн юм шиг болж, сэтгэл санаа тайвшран, баяр хөөрөөр оволзох шиг үнэхээр сайхан болж гэнэ. Ингээд нутгийн хүмүүс мөнх ногоон цайны ургамлын гайхамшигт чанарыг нээн илрүүлсэн домог үүсчээ. (ЦАС, 10)

“Цай” гэж нэрлэгдэх болсон хүний бие махбод, сэтгэл санааг сэргээн сайжруулах уддис агуулсан ундааны тухай эртний судар бичигт, тухайлбал бүр МЭӨ-2700 онд буюу одоогоос 5000 орчим жилийн өмнөх үеийн гар бичмэлд дурдагдсан байдаг. Тэр үед цайны навчаар бэлтгэж, ханд нь гашуун амттай байв. Энэ хандыг тусгай амтлагч хийсний дараа л сая ууж, болдог байсан ажээ. Цай гэгч ундааг энэ үеэс дангаар нь цангаагаа тайлахын тулд ууж, өлсч байгаа үедээ ч хэрэглэдэг болов.

Тэгвэл Монгол оронд минь цай нь бүр эрт буюу XIII зуунд Чингис хаан Монголын эзэнт гүрнийг байгуулах урт удаан хугацааны аян дайнд хээрийн цайгаа ууж, алжаалаа тайлан, өөрийн оюун ухааныг хурцалж явсан билээ. Харин түүний ач Хубилай хаан Юань гүрний нийслэлийг эртний Даду буюу өнөөгийн Бээжин хотод байгуулсан бөгөөд өөрийн ордонд идээ болон хүндэтгэлийн цайг ордны тусгай ёс жаягаар хүртэж байв. (ЦАС, 95)

“Цай” гэж чухам юу болохыг дараах тодорхойлолтоос харна уу.

“**цай**”- зарим ургамлын хатаасан буюу боловсруулсныг усанд буцалгаж идээшүүлэн уух ундаан (МХТТТ, 780), чай (БАМРС, 246), цайны модны навчийг идээшүүлсэн унд (МХДТТ, 2880), унданд хэрэглэхээр боловсруулан хэвлэсэн буюу савласан, цайны модны навч (ОБМНАСМҮД, 891), цайны модны навчийг идээшүүлсэн унд (МХХТТБ, 926). Тэгэхээр бидний өдөр тутам хэрэглэж байгаа цай нь модны навчаас гаралтай юм. (АЦЖ, 9)

“Цайны алтан судар”, “Амтаг цайны жор” хэмээх ном судар, тайлбар толь бичгүүдээс бидний бүрдүүлсэн баримтаас үзэхэд, цай гэх үг *тэмдэг нэр+цай* бүтцээр нийлэмж үүсгэсэн нь 61 байна. Эдгээр нэр бүр цайны өөр өөр төрөл зүйлийг заасан ба өөрөөр хэлбэл, монгол үндэстэн ястнуудын амьдарч буй нутгаас шалтгаалан цай нь өөр өөр байна. Тухайлбал:

1. “**хорхогтой цай**”- усаа буцалгасны дараа таглаа сайтай саванд юүлж, дээрээс нь аргалын галд улайсгасан чулуу хийж бигүү таглана. Хагас цаг болоод тагийг болгоомжтой онгойлгон, цайг юүлж авна. Ийм цайг ядаргаа арилгахад сайн гэж гэр орны тав тухтай нөхцөлд ууж, хөлсөө сэвхийхээс болгоомжилно. Төв аймаг орчмын ард энэхүү цайг уудаг. (АЦЖ, 10)

2. **Увс нутгийн “жимбүүр цай”**- булгийн усыг буцалган, нунтаглаж нүдсэн цайны идээ хийж идээшүүлдээд, түүхий сүүгээр сүлж, давс, хужир нэмж самарна. Ширмэн тогоонд чанана. Зуугаад удаа самарсан ийм цай ядаргаанд сайн гэдэг. (АЦЖ, 11)

3. **Баян-Өлгийн “өлгий цай”**- ус, түүхий сүү, цайны идээ, шар тос, давс хужрыг зэрэг хийж самрахгүй чанана (АЦЖ, 11)

4. **Дундговь аймгийн “Мандалговь цай”**- цэвэрлэсэн шар будааг дэвтээж нүдээд шар тосонд хуурна. Дээр нь тунгаасан цай, мах хийж буцалгана. Мах, будаа болсны дараа сүлж, давс хужир хийж, сайн самарч буцалгаад уудална. (АЦЖ, 11)

5. **Хөвсгөл нутгийн “цааган цай”**- зод модны холтсыг сайн хатааж, хуурайгаар үрж нунтаглаад шигшиж, түүнийгээ усанд хийж, самарна. Буцалгаж ухаа ягаан өнгөтэй болоход сүлж сайн самраад, буцалгаж уудална. (АЦЖ, 11)

6. “**ястай цай**”- хийцтэй юмуу хийцгүй цайнд дунд чөмөг, атгаал чөмөгний ясыг хугалж хийгээд буцалгана. Сүлэхийн өмнө ясыг хийж нэг цаг орчим буцалгасны дараа сүлж, бага зэрэг мах үйж болно. Ингэж буцалгасан цай амт чанар сайн, тэжээллэг гэж говьчууд их чанадаг. (ЦАС, 86)

7. “**Ховд цай**”- тосолсон халуун тогоонд сүү хийж, дээрээс нь нунтаг цай нэмэн зөөлөн галаар буцалгана. Дараа нь ус хийж буцалгаад давс, хужир, шар тос хийж сайтар самарна. Ааг ихтэй, өтгөн шаргал ийм цайг Ховд нутагт чанадаг. (ЦАС, 87)

8. “**толгойн ястай цай**”- хонины толгойн гавлын ясыг хагалж аваад, бэлэн болсон сүүтэй, хийцтэй цайндаа хийж чанадаг. Ийм цайг Төв аймгийнхан чанах дуртай. (ЦАС, 87)


9. **Сэлэнгийн “бор цай”**- ширмэн тогоонд шар тос, давс, цайны идээ, гурил хийж хуурсны дараа ус нэмж самран буцалгана. Буцалгасан цайг аягалахдаа түүнд нимгэн хярсан түүхий мах 3-4 ширхэг хийгээд дээрээс нь аяга хөмрөн таглаад 2-3 минутын дараа уухад биеийн алжаал тавигддаг гэж настан буурлууд ярьдаг. Шаргал бор өнгөтэй, сайхан амттай ийм цайг Сэлэнгэ нутгийнхан чанадаг. (ЦАС, 87)

10. “**Цагаан будаа, борцтой цай**”- цагаан будаагаар хийцэлж борц хийж чанасан амт чанар сайтай энэ цайг говь нутгийнхан их чанадаг. (ЦАС, 87)

Г.Ганзул

Баруун зүгийн аймгийнхан сүүтэй цайнд давс, хужир хийдэг бол зүүн аймгийнхан хийдэггүй онцлогтой. (АЦЖ, 9)

Түүнчлэн тэмдэг нэр-цай нийлэмж нь цайны олон төрлийг илэрхийлдэг ба үүнийг дараах бүдүүвчээр харуулан, тайлбарыг бичив.



Бүдүүвч 2

1. “**аагтай цай**”- крепкий чай (БАМРС, 246) (орч. өтгөн цай)
2. “**байхуу цай**”- байхуу ургамлаар хийсэн нэг зүйл цай, хурган цай ч гэнэ (МХТТГ, 780), байхуу ургамлаар хийсэн нэгэн зүйл цай, хурган цай (МХДТГ, 2881)
3. “**банштай цай**”- цайг усанд идээшүүлээд шаарыг шүүж авсны дараа урьдчилан бэлтгэсэн банш болон сүү хийж буцалгаад, баншийг болмогц аягална (АЦЖ, 12)
4. “**борви, тойгоны ястай цай**”- борви, тойгоны ясыг нүдсэн цайны хамт хүйтэн усанд хийж, зөөлөн галаар 30 минут буцалгасны дараа сүлж, самарч давс нэмнэ (ЦАС, 87)

Г.Ганзул

5. **“борцтой цай”**- идээшүүлсэн хар цайны шаарыг тунгаасны дараа борц, сүү, давс хийж, огцом буцалгана (АЦЖ, 12)
6. **“бүтээн цай”**- чай с небольшим количеством молока (БАМРС, 246) (орч. сүү багатай цай)
7. **“будаатай цай”**- чай заправленный, пшеном или рисом (БАМРС, 279) (орч. цагаан будаа эсвэл шар будаагаар найруулсан цай)
8. **“будаа, сүүлтэй цай”**- шаарыг тунгаасан хар цайг тогоонд эргүүлж хийгээд дээр нь будаа, үелж хэрчсэн хонины сүүл хийж зөөлөн галаар чанаж болгоно. Будаа, сүүл болохын хамт, түүхий сүүгээр сүлж, давс хийж сайн самарна. Дараа нь үе сүүлийг цайнаас гаргаж нимгэн зүсэн аяганд хийж цайтай хамт өгнө. (ЦАС, 87)
9. **“буурцаг цай”**- горный чай, дикий чай (БАМРС, 296) (орч. уулын цай, зэрлэг цай)
10. **“гонидтой цай”**- гонидоор амталсан банштай, сүүтэй цай. Өвөрхангай нутгийнхан чанадаг. (АЦЖ, 14)
11. **“загасгалтай цай”**- манай говийнхон энэ цайг уух дуртай. Зун, намрын цагт загасгалыг түүж хатаана. Хатаасан загасгалыг бэлэн болсон сүүтэй ба хийцтэй цайнд хийж буцалгана. Цай буцлаад шар ногоон өнгөтэй болмогц бэлэн болно. Цайгаа шүүж аягална. Загасгал гэдэг нь бутлаг ургамал болно. Нунтаглахын зэрэгцээ ганц хоёр мөчрөөр нь цайндаа хийж болно. Бага зэрэг шар тос, сүү, давсыг сонирхолдоо нийцүүлэн хийнэ. (АЦЖ, 15)
12. **“зузаан цай”**- цайны навчийг засварлан болгож хэвт шахан хийсэн хэвлэмэл цай (МХТТГ, 283)
13. **“зугангай цай”**- чай - болтушка (заправленный мукой и маслом) (БАМРС, 240) (орч. гурил тостой хольсон цай)
14. **“идээшмэл цай”**- заваристый чай (БАМРС, 265) (орч. идээшсэн цай)
15. **“ногоон цай”**- шахмал цай (МХТТТ, 379)
16. **“сүүтэй цай”**- сүүлсэн цай (МХТТТ, 780), чай с молоком (БАМРС, 246), сүүгээр сүлсэн цай (МХДТТ, 2881)
17. **“тунгалаг цай”**- дэвтээж идээшүүлсэн цай (МХТТТ, 557), чистый чай (БАМРС, 254)
18. **“түүхий сүүний цөрөмтэй цай”**- усан дээр цөрөм хийж, сайн самраад, цайны идээ, хужир хийж буцалгана. Өвлийн хүйтэнд малчин хүн уухад нэн тохиромжтой. (АЦЖ, 12)
19. Эдгээр уламжлалыг баяжуулан, ард түмэн олон янзын цай чанаж уудаг болж байна. Түүний нэг нь **“өндөгтэй цай”** юм. Тодруулбал, усанд түүхий өндөг хийж хутгаад буцалтал самрахад сүүтэй мэт болно. Дээрээс нь цэвэр даавуун ууттай идээ, давс, сүүг зэрэг хийж самраад буцалгаж уудална. Ийм цайг халуун дээр нь уухад ядаргаанд сайн гэдэг. (АЦЖ, 16)
20. **“өтгөн цай”**- крепкий чай, густой чай (БАМРС, 246) (орч. өтгөн цай)
21. **“улаан цай”**- крепкий с молоком чай, плохой чай, чай низкого сорта (БАМРС, 318) (орч. сүүтэй өтгөн цай, муу цай, муу төрлийн цай)
22. **“халх цай”**- будааг нунтаглан шар тосонд хуурч, шаарыг нь тунгаасан халуун хар цайгаар цоргин сүлж, давс, хужир, нэмэн сайтар самраад буцалгана (ЦАС, 86)
23. **“хар цай”**- нэгэн зүйл цай, шахмал задгай хоёр зүйл бий (МХТТТ, 660), сүлээгүй цай (МХТТТ, 780), (чёрный) чай без молока, незабалённый молоком чай (БАМРС, 45), сүүгүй цай

(МХДТТ, 2881)

24. “**халгайтай цай**”- халгайг 4-5 салаатай (5-6 дугаар сард) ургасан нялх үед нь түүж хатаана. Хатаасан халгайг нүдэж нунтаглаад тосонд бага зэрэг хуурч сүүтэй цайндаа хийж, сайн самарч буцалгана. Нүдсэн халгайг 3 литр цайнд хоолны халбагаар гурвыг хийнэ. Цайндаа мах, сүүлээр амт оруулна. (ЦАС, 87)

25. “**хагуу цай**”- шахмал цай (МХТТТ, 780), шахмал цай (МХДТТ, 2881)

26. “**хийцтэй цай**”- хийцэлсэн цай (МХТТТ, 780), чай заправленный мукой и маслом (БАМРС, 246), хийцэлсэн цай (МХДТТ, 2881)

27. “**хомбоо цай**”- урт бөөрөнхий хэлбэртэй шахсан цай (МХТТТ, 688), продолговато круглый зелёный чай (БАМРС, 103)

28. “**хонины сүүлтэй цай**”- хонины сүүлийг хөшиглөөд хуурай цайтай хамт ууранд хийж нүднэ. Тогоотой халуун усан дээр сүүлтэй нүдсэн цай болон сүү, давс хийж 30-35 минут буцалган сайтар самарна (ЦАС, 87).

29. “**хоосон цай**”- уух, идэх юмгүй дан цай уух (МХДТТ, 2881)

30. “**хээрийн цай**”- а. уулын цай; б. аян замын цай (МХДТТ, 2881)

31. “**чулуун цай**”- хагуу цай (МХТТТ, 780)

32. “**шар будаа, гурилтай цай**”- шар будааг гурилтай хамт шар тосонд 3-4 минут хуураад, дээр нь шүүсэн хар цай хийж зөөлөн галаар 35-40 минут чанаж гүүхий сүүгээр сүлж сайтар самран буцалгаж удална (ЦАС, 87)

33. “**шар тос самарсан цай**”- ерийн чанасан цайг уудлахаас өмнө шар тос хийж, сайтар самарна. Ийм цай анхилам сайхан үнэртэй болдог. (АЦЖ, 13)

34. “**шингэн цай**”- спитой чай, жидкий, слабый чай (БАМРС, 46) (орч. чанасан шаар, шингэн цай)

Эндээс үзвэл, монголчууд олон төрлийн цай хэрэглэдгийг харж болно. Монголын ард түмэн цайг буцалгаж уудаг. Үүний нэг жишээ нь “хар цай” ба “сүүтэй цай юм”. Өвөл, хаврын улиралд малын сүү сааль татарч, хөлдөөж, хурааж, нөөцөлсөн сүү хүрэлцээгүй, эсвэл сүүгүй үед хар цай уудаг. Түүнчлэн хөдөө мал сүрэнгүй айл хар цай уудаг бөгөөд гэд зочид, гийчдийг хар цайгаар дайлдаггүй аж. (Г. Томтогтох, 2000, 18) Сүү хүндэтгэлийг илэрхийлдэг учир зочдыг сүүтэй цайгаар дайлдаг. Мөн монголчууд ус, давс, сүү, тос, цай оролцсон цайг 5 тансагт цай гэж үздэг байна. Энэ нь тухайн ард түмний ахуй, соёл, өвөрмөц сэтгэлгээтэй холбоотой.

Цай+үйл үг нийлэмж 28 байгааг доорх хүснэгтээс үзнэ үү. Энэ нь монголчуудын амьдралын хэв маягтай шууд холбоотой юм.

Хүснэгт 2

№	Цайгай холбогдох үйл үг	Тайлбар
1	Ааггүйдэх	хэтэрхий ааггүй болох, ааг амт нь нилээд сулчир тохиромжгүй болох (МХХТТ, 1), ааг нь нилээд багадах (МХТТТ, 11)
2	Цай амтлах	цайнд давс хужир, сүү хийж удтал самрах (МХДТТ, 2880)
3	Цай аягалах	цай аяганд хийх (МХДТТ, 2880), аяганд идээ, ундаа хийх (МХХТТБ, 49)

Г.Ганзул

4	Цай балгуулах	балгахын үйлдүүлэх хэв; бага сага юм уулгах; <i>цай балгуулах</i> (МХТТТ, 71)
5	Цай барих	а. ахмад хүмүүс. зочин гийчинд цай өгөхийн хүндэтгэл; б. цай зооглох (МХДТТ, 2880), хүндтэй буюу ахмад хунд зориуд урьж цай хоол өгөх (МХТТТ, 780)
6	Цай богших	шөл, цай зэрэг шингэн юмын өтгөрөн хандших, борших (ОБМНАСМУД, 226), борших, хандших (МХТТТ, 87)
7	Цай борших	цай аагших (МХХТТБ, 91), шингэн юмны чаналт нь хэтэрснээс болж дэндүү хурц амттай аагтай өтгөн болох (МХТТТ, 95)
8	Цай буудах	айлын цай чанаж байхад нь тааруулж очих - Өнөөх айлд орьё уу, өглөөний цайг буудъя уу. Д. Нацагдорж. Хүргэн хүү. (МХДТТ, 2881)
9	Цай дэврэх	шингэн буцламгай юмны савнаасаа халих; тогоотой цай дэврэх (МХТТТ, 220), цай буцалж савнаасаа халих (МХХТТ, 241)
10	Цай залах	цайны шаарыг ариун идээ хэмээн хүндэлж, гэрээс баруун зүгт асгах (МХДТТ, 2880)
11	Цай зутагнах	цай нийцлэх (МХДТТ, 2880)
12	Цай идээших	юмны шим шүлт юманд бууж шингэх, цай идээших, эм идээших (МХТТТ, 301), цай аагших (МХХТТБ, 348)
13	Цай идээшүүлэх	идээг нь буутал чанаж, амт өнгө нь таарах (МХДТТ, 2880)
14	Нүдэх	нүдүүрээр дэлдэж няцлах, нунтаглах; <i>цай нүдэх</i> (МХТТТ, 392), нүдүүрээр дэлдэж няцлах, нунтаглах (МХХТТБ, 455)
15	Халуун цай оочих	багаар сорж уух (МХТТТ, 420), халуун цайг хурдан хурдан сорж уух (МХХТТБ, 485)
16	Цай өргөх	чанасан цайны дээжээр цацал өргөх, цөгцөнд хийж, тахил тавих (МХДТТ, 2880)
17	Цай самрах	цайг сүлж, шанага мэтээр утган дээрээс асгах (МХДТТ, 2880), шингэн зүйлийг шанага мэтээр утган авч, дээрээс буцааж асгах; <i>сүү самрах; цай самрах</i> (МХТТТ, 466)
18	Цай сүлэх	цайнд сүү хийж самрах (МХДТТ, 2880), цай мэтэд сүү холих; цай сүлэх (МХТТТ, 495), бор цайн дээр сүү нэмж холих (МХХТТБ, 581)
19	Цай гэвхлэх	цай дөрвөлжин хуваах (МХХТТБ, 683)
20	Уудлах	шингэн зүйлийг нэг савнаас нөгөө сав руу утган авч хийх; цай уудлах; хөхүүрээс хувинд айраг уудлах (МХТТТ, 604)
21	Цай уух	шингэн юмыг балгаж залгих; цай уух (МХТТТ, 607), цай балгалах (МХХТТБ, 729)
22	Цай уулгах	айлчин гийчнийг урьж, цай өгөх (МХДТТ, 2880)
23	Цай үйх	цай чанах гэж байгаа тогоотой усанд нүдсэн цай орхих (МХДТТ, 2880), гал дээрх тогоотой усанд цайны идээ хийх, чанах (МХХТТБ, 744)
24	Цай чанах	аливаа юмыг буцалгаж боловсруулах; <i>цай чанах; хоол чанах; жимс чанах; чанасан мах; чанасан будаа</i> (МХТТТ, 813), аливаа юмыг буцалгаж боловсруулах (МХХТТБ, 962), цай буцалгах (МХДТТ, 2880)

Г.Ганзул

25	Цай хандлах	ханд болгох, удаан буцалгаж шимийг шингээн авах; эм хандлах; цай хандлах (МХТГТ, 658), цай, шөл зэргийг удаан буцалгаж ширгээн шимийг шингээж авах (МХХГТБ, 790)
26	Цай хийх	а. цай чанах; б. цай аягалах; в. цай үйлдвэрлэх (МХДГТ, 2880), а. цай боловсруулан үйлдэх; б. цай чанах; в. цай аягалах (МХГТГ, 677)
27	Цай хийцлэх	шар тос, зөөхий, гурил, будаа хуурмаглан, арвайн гурил орхиж цайг амтлах (МХДГТ, 2880), уушны зүйлийг зутагнаж чанаржуулах; <i>цай хийцлэх</i> (МХГТГ, 677), цай зутагнах (МХХГТБ, 814)
28	Шингэрэх	шингэн болох; <i>цай шингэрэх</i> (МХТГТ, 848)

Дээрх жишээнээс анхаарал ихээр татсан жишээ бол “цай хандлах” юм. Учир нь “цай хандлах” гэдэг нь зүгээр буцалсан усанд цайг удаан дэвтээхийг хэлээгүй, харин цайгаа “удаан буцалгаж, ширгээн шимийг авах”-ыг хэлжээ. Гэтэл гадаадын тухайлбал, оросын ард түмэн “цайг хандлах” буюу “заварить чай” гэвэл тэд буцалгахгүй, эсрэгээрээ идээгээ буцалсан усанд дэвтээх гэж ойлгоно. Түүнчлэн “цай тэвхлэх” гэх нийлэмж нь харийн хүмүүст мөн л ойлгомжгүй. “Тэвхлэх” гэх үйл үг нь “юмыг дөрвөлжин болгож хэрчих”-ийг хэлнэ.

Мөн “цай самрах” нийлэмж нь олон удаа самарч, хөх тэнгэр, орчлон хорвоогийн эрүүл мэндийг тэтгэгч их нууц хүчийг цайндаа шингээдэг заншилтай. Энэ нь нэг талаас цайнд хүчилтөрөгчийг сайтар шингээж байгаа явдал бөгөөд нөгөө талаас цайны усыг идэвхжүүлж, улмаар цайг биологийн идэвхт ундаа болгосноор түүний бие махбодод нөлөөлөх чанар нь улам сайжирдаг байна. (ЦАС, 94)

“Цай үлх, цай хийцлэх”, г.м. нийлэмж нь бүгд л мөнгөлдчүүдийн цай чанах уламжлал, байгаль, цаг уур, амьдралын хэв маягтай салшгүй холбоотой юм. Мөн дээрх жишээ нь хэл нь соёлын тусгал болж байгаагийн илрэл, баримт болох билээ.

Хүснэгт 3-аас “цай” гэх үг нь үйл үгтэй холбогдож байгаагаас гадна нэр үгтэй холбогдож байгааг харж болно. Монголын ард түмэн эхлээд цайгаа ууна. Дараа нь зоог, хоолоо иддэг билээ. Тиймээс хэрэглээний үүдэлтэй “цай будаа”, “цай зоог”, “цай зууш”, “цай шөл” гэх зэрэг нь зочин гийчнийг ирэхэд хамгийн түрүүнд цайгаа өгч, дараа нь идээгээр дайлдаг уламжлалтай билээ.

Хүснэгт 3

№	Цай+нэр үг/ нэр үг +цай нийлэмж	Тайлбар
1	Цай будаа	хоршоо. Унд болон идэх зүйл - Олон амьтнаа сэргээж босгоод цай будаагаа идэв. Монгол ардын домог үлгэр. (МХДГТ, 2881)
2	Цай зоог	хоршоо. Унд хоол - Чи буруугаа мэдвээс цай зоог авч, цаазыг хүртээхээр ирэгтүн. Замлин Сенчиний намтар оршив. (МХДГТ, 2881)
3	Цай зууш	хоршоо. Унд болон хөнгөн маягийн хоол - Хурсан зочдын цай зууш бэлтгэмүй. В. Инжиннаши. Улаанаа ухилах тэнхим. (МХДГТ, 2881)
4	Цай унд	хоршоо. Унд хоол - Үүнээс хойш явдлын хүнд заавал цай унд хийж өгдөг заншил тогтсон юм гэнэ. Торгууд, захчин ардын тууль үлгэр. (МХДГТ, 2881)
5	Цай цүй	Идээ унд - Мэнд ус мэдэлцэж, цай цүй, идээ будаа идэх зуур... Б. Ринчэн. Монгол бичгийн хэлний зүйн удиртгал. (МХДГТ, 2881)
6	Цай шөл	хоршоо. Унд хоол - Нэгэнтээ ирснийх цай шөл зооглож харивал яана. Арван гурван хүлгийн дуун. (МХДГТ, 2881)

7	Идээ цай	хоршоо. Тавгийн идээ, унд цай (МХДТТ, 2881)
8	Унд цай	хөнгөн маягийн хоол, унд (МХДТТ, 2881)

Хятадын цай боловсруулах арга технологи болон цайны жорыг өвөрмөц боловсронгуй болгон, төв Азийн нүүдэлчдийн хэрэгцээнд зохицуулсан улс бол эртний монголчууд юм. Монголчууд алс холын аян зам, нүүдэлд зориулан бутархай цайны навчийг зузаан дөрвөлжин хэлбэртэй болгон шахаж боловсруулдаг аргыг олжээ. Тиймээс энэхүү дөрвөлжин шахмал цайг тэмээнд тэгнэж, арьсан богцонд хийж, морин дээр авч явахад нэн тохиромжтой болсноос гадна цайны амт, чанарыг алдагдуулахгүйгээр удаан хугацаагаар хадгалан хэрэглэх боломжийг олгосноор ногоон цайг хятадаас тэмээн жингээр Дундад Ази, Арабын орнууд, Монгол, Орост зөөвөрлөдөг байв. Үүнтэй уялдуулан XVII-XVIII зууны үед цайтай холбогдолтой оньсого, таавар ч бий болсон байна. Жишээ нь: бага хээр морь, баруун хаандаа тамгатай /цай/


дөв дөрвөлжин, дөрвөн ойрдын хүслэн /шахмал цай/

хэлтгий бие, хэнд ч бараалхана /домботой цай/ г.м. (ЦАС, 103-104)

Бүдүүвч 3-аас цайг уух ундаар биш, харин мөнгийг илэрхийлдэг нэгж байсныг харж болох юм.

Манай тооллын өмнөх I зуунд оршин тогтнож байсан Хятадын Хань улсын үед цайг худалдаа наймааны бараа болгон хэрэглэж байсан түүхтэй. Энэ нь VII-X зууны үед Төвдийн өндөр уулсад тархсан байна. (ЦАС, 13) Тэгвэл монголд XVII-XVIII зууны үед мөнгөний оронд хэрэглэж байжээ.

Тэмдэг нэр+цай нийлэмж нь 5 байгаа бөгөөд дээр өгүүлснээр эрт үед монголчууд худалдаа, арилжаа хийхдээ “сэвэг цай”, “сул цай”, “чулуун цай”, “шар цай”, “хөл цай”-г мөнгөний оронд хэрэглэдэг байжээ. Өөрөөр хэлбэл, “цай” нь мөнгийг орлож байсан нэгж юм. Дараах жишээг харна уу.



эхгүй шар цай (МХДТТ, 2881)

“сэвэг цай”- 800 шар цай (МХДТТ, 2881)

“хөл цай”- 12-20 зууны эхэн хүртэл, халхын зарим нутагт аливаа алба ноогдуулахдаа хонь нэг бүрд нэг шар цай, адуу үхэр тус бүрд 4-өөс 6 шар цай, тэмээ бүрд 6-8 шар цай оноож байсныг хэлж байжээ (МХДТТ, 2881)

“чулуун цай”- булан цай, нэг чулуун цай 30 шар цайтай тэнцэнэ, хатуу цай (МХДТТ, 2881)

“шар цай”- шахмал ногоон цайг найм хуваасны нэг буюу цаасанд боосон задгай цай, ийм 10 шар цай нэг тэмээ, 8 шар цай нэгжгээд үхэр, адуу, хоёр цай нэг хоньтой тэнцэж байжээ (МХДТТ, 2881), шахмал ногоон цайг 8 хуваасны нэг, хуучин цагийн мөнгөний нэгж болох цаасанд боосон задгай цай (МХТТТ, 838), одна восьмая часть зелёного кирпичного чая, старинные бумажные денежные единицы, низшая денежная единица, равнявшаяся одной засыпке кирпичного чая (БАМРС, 341)

Цайны+нэр үг нийлэмж нь цай уухад зориулан хийсэн, эсвэл цайтай холбоотой гэсэн утгыг илэрхийлж буй 9 үг байна. Жишээлбэл, цайны аяга, цайны газар, цайны дээж, цайны зориг, цайны идээ, цайны таарцаг, цайны халбага, цайны шаазан, цайны шаар, Тайлбарыг дэлгэрэнгүй авч үзье.

1. “цайны аяга”- цай уухад зориулагдсан аяга (МХДТТ, 2880)

2. “цайны газар”- цай хоол идэж уухад зориулсан газар (МХДТТ, 2880)

3. “цайны дээж”- чанасан цайны охь, цайны дээжийг эхлээд бурхан тэнгэртээ өргөж, дараа нь бурхандаа, дараа нь гэрийн эзэн, зочинд аягална (МХДТТ, 2880), ямар нэгэн юмнаас тусгай зорилгоор охь хувь болгон авсан юм; *цайны дээж* (МХТТТ, 230)

4. “цайны зориг”- цайны дээж (МХДТТ, 2880)

5. “цайны идээ”- хуурай цай, цайны ханд шим (МХДТТ, 2881)

6. “цайны таарцаг”- цай хийж агуулах, уут сав (МХДТТ, 2881)

7. “цайны халбага”- цай уухад хэрэглэх жижиг халбага (МХДТТ, 2881)

8. “цайны шаазан”- цай уухад зориулагдсан шаазан аяга (МХДТТ, 2881)

9. “цайны шаар”- цай болгосон шаар, шим шүлтгүй үлдэгдэл (МХДТТ, 2881)

Мөн *цайны+нэр* үг нийлэмж нь өөр утгыг агуулж байна. Тухайлбал, “цайны дээл” гэдэг нь гоёлын дээл - Салаа гэгээ дагнан сүлжиж, сар сувдан даруулгаа зүүлээ, Цайны дээлээ нөмгөн өмсч, царай зүсээ тольдон заслаа, Д. Пүрэвдорж. Хөх дааламбан тэрлэг. (МХДТТ, 2880) Бид өөрт байгаа нандин, цорын ганц зүлийг цайны хувцас, цайны гутал гэж хэлдэг билээ. Түүнчлэн “цайны дээж”-ийг өөрөөр “цайны зориг” гэдэг байна.

Дараачийн нэг жишээ бол “цайны мөнгө”- томилолтоор ажиллах үед ойр зуур хэрэглэх зардал. (МХДТТ, 2881) Тэгвэл өнөө үед “цайны мөнгө” гэх ойлголт нь томилолтын зардал гэж ойлгогдохоос гадна гар цайлгах мөнгө гэж ойлгодог. Энэ нь мэдээжийн хэрэг даяарчлагдаж байгаа нийгэмтэй холбоотой юм. Монгол орныг зорин ирэх жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж байгаа одоо үед тэдний сэтгэлд нийцсэн, сайн үйлчилсэн зоогийн газрын зөөгч нарт “цайны мөнгө” өгдөг билээ. Тогтсон мөнгөний тоо хүртэл тэдэнд бий. Энэ нь монгол соёлд нэвтэрч байгаа бас нэг үзэгдэл юм.

Г.Ганзул

Дээр өгүүлсэн бүхнээс дүгнэж үзвэл, хэл, бүр тодруулж хэлбэл, тодорхой хэлний үгийн сангийн нэгж нь уг ард түмний соёлыг илэрхийлдэг хүчин зүйл болно. Мөн амьдралын туршлагаас үүдэн бий болсон хэлний нэгжийн нийлэмж нь тодорхой утга, агуулгатай бөгөөд өөр орны соёлтой нийцэхгүй, өвөрмөц онцлогтой. Түүнээс улбаалан ард түмний дунд 1690-ээд оны үед цайтай холбоотой оньсого таавар ч бий болжээ (бэх шиг хар, бичиг шиг дөрвөлжин /шахмал цай/ г.м).

Бидний авч үзсэн жишээ баримтаас үзэхэд, монголын ард түмэн эрт дээр үеэс “Бурхадын ундаа” хэмээн цайг дээдэлж, цайны соёлтой байсан нь харагдаж байна. Монголын 20 үндэстэн ястан амьдарч буй нутаг, цаг уураас шалтгаалан цайг олон янзаар ууж, хэрэглэж иржээ. Жишээ нь: “Дарьгангын будаа орхисон цай”, “Захчингийн хар данхтай цай”, “Халхын хорхоглосон цай”, “Дөрвөдийн өглөгчийн шар цай” зэрэг сайхан амт, үнэртэй цай юм. Үүнтэй уялдуулан “цайлах” ёс бий. Түүнээс цөөн хэд нь дурдъя. Гэрийн эзэгтэй чанасан чайныхаа дээжийг эхлээд хангай дэлхий, бурхандаа өргөж, дараа нь настан буурал, өрхийн тэргүүн гэсэн дарааллаар барьдаг. Зочин ирэхэд заавал 5 тансаг идээний дээд гэж цай чанаж, аягалах нь зочноо хүндэтгэж буй хэрэг юм. Түүнчлэн, монголчууд цайг сэтэрхий аяганд аягалж өгдөггүй. Цайг заавал хоёр гараараа барьж, гардаж авдаг. Эсвэл зүүн гарын алгаар баруун гарын тохойг түшин авч өгөлцвөл, хүндэтгэлийн гэрч болно.

Цайг зөвхөн уух ундаа бус, түүнчлэн ядаргаа арилгах, аливаа өвчин эмгэг, хавдар, ханиад томууг анагаах, урьдчилан сэргийлэх зорилгоор цайг хэрэглэж иржээ. Жишээлбэл, бидний өргөн хэрэглэж заншсан “нохойн хошууны цай”, “шар луувангийн цай”, “анисны цай” зэрэг болно. Тиймээс цайг цаашид өдөр тутмын ба эмчилгээний гэж ангилан үзэх шаардлагатай бөгөөд ямар цайг аль нутагт өдөр тутам уудаг вэ? гэсэн асуултын хариуг олох шаардлага зайлшгүй гарч байна.

Даяарчлагдаж байгаа өнөө үед Монголд цайны төрөл олширсоор байгааг тэмдэглэх нь зүйтэй. Жишээ нь: жасмин цай, эмчилгээний тураах цай, дүрдэг байхуу болон ногоон цай, жимстэй цай, хүн орхоодойн цай нь олноороо импортоор оруулж байна. Улс орон хөгжихийн хэрээр цайны соёл, монгол ёс заншил зэрэг нь өөрчлөгдөж байна. Тухайлбал, сүүлийн үед дүрдэг Хөвсгөл цайг үйлдвэрлэдэг болсон билээ. Хэдийгээр энэ нь амьдралд хэрэглэхэд амар, авсаархан, боломжийн боловч, энэ нь эргээд соёлыг устгах хүчин зүйл болно. Тиймээс 300-аад жилийн түүхтэй, дэлхийд гайхагддаг Японы цайны ёслол шиг монголчуудын цай чанах уламжлал, цайны хэрэглээ, цай аягалах ёс зэргийг үеэс үед өвлүүлэн үлдээх зорилгоор Монгол улсын засгийн газраас бодлого хэрэгжүүлэн, цайны судалгааны төвийг нээн байгуулж, цайны соёлыг олон нийтэд түгээж, хадгалах нь чухал болоод байна.

Бидний энэхүү судалгаа ард түмний соёл хэлэндээ шингэж, хэл эргээд энэхүү соёлын илэрхийлэл болдгийн тод жишээ юм.

Г.Ганзул

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

1. “Большой академический монгольско - русский словарь”- (БАМРС)
2. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” - (МХДТТ)
3. “Монгол хэлний товч тайлбар толь” - (МХТТТ)
4. “Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг” - (МХХТТБ)
5. “Оюун билгийн мэлхийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж”- (ОБМНАСМҮД)
6. Орч. - орчуулга
7. ЦАС- Цайны Алтан Судар
8. АЦЖ- Амтат цайны жор

Г.Ганзул

НОМ ЗҮЙ

1. Амаржаргал П. “Цайны алтан судар буюу энх мөнхийн цай” ДА., 2004
2. Арьяасүрэн Ч. “Монголын ёс заншлын их тайлбар толь” УБ., 2001
3. Баянсан Ж. “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ” УБ., 2002
4. Гонгоржав Г. “Амтат цайны жор” УБ., 1992
5. Дамбажав И. ба бусад. “Оюун билгийн мэлмийг нээгч аялгуу сайхан монгол үгийн дээж” УБ., 2006
6. Ерөнхий редактор Болд Л. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь” УБ., 2008
7. Лувсандэндэв А., Цэдэндамба Ц. “Большой академический монгольско - русский словарь” М., 2001
8. Монсудар хэвлэлийн газар “Монгол хэлний хураангуй тайлбар толь бичиг” УБ., 2009
9. Нансалмаа Н. “Үг, ухагдахуун, үгийн тайлбар дахь соёлын хүчин зүйл”., Гадаад хэл заах арга зүйн асуудалд №2., 2002
10. Нансалмаа Н. “Үгийн сан судлал” УБ., 2005
11. Нансалмаа Н. “Хэлшинжлэлийн судалгааны арга зүй” УБ., 2011
12. Равдан Э. “Орчин цагийн хэлшинжлэл”, УБ., 2005
13. Равдан Э. Хэл соёлын шүтэлцээний тухай // МУИС.ГХСС. ЭШБ 2001 №170/1. х.5-34
14. Томтогтох Г. “Лексико - семантическое исследование монгольских реалий”. Автореф. дис. на сонск. Уч.ст. Д-ра. (Ph.D) фил.наук. УБ. 2000 г.
15. Хөхлүү “Идээ ундааны жинхэнэ товч” ӨМ., 1965
16. Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь” УБ., 1966
17. Верещагин Е. М. Костомаров В. Г. “Язык и культура” Изд. 4-е М., 1990
18. Комлёв Н. Г. Слово, денотация, картина мира // В Ф. 1981, №11 с.25-37
19. Ладо Р. Лингвистика поверх границы культур // Новое в зарубежной лингвистике. Вып. XXV. М., 1989
20. Серебренников Б.А., Кубрякова Е.С., Постовалова В.И. и др. “Роль человеческого фактора в языке: язык и картина мира” М., Наука, 1988.
21. Юрий Кручкин “Монгол – Орос, Орос – Монгол толь бичиг”, УБ., 2011 г.
22. Chomsky N. “Language and Thought” Moyer Bell 1993.
23. George Lakoff. “Ten lectures on Cognitive Linguistics”, 1991